

МОНГОЛЫН БАРУУН БҮС НУТАГ ДАХЬ ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН ТАРХАЛТ, ТӨЛӨВ БАЙДАЛ

Ц.Пүрэвсүрэн (Ph.D)
Ховд Их Сургууль

Түлхүүр үгс: *шашны байгууллага, шашны байгууллагын үйл ажиллагаа, шашны нөлөө*

Товч утга: *Эдүгээ Монгол оронд 1990-ээд оноос шашин шүтэх эрх чөлөө нээлттэй болсонтой холбогдон дан ганц шашингүйн үзэл ухамсар, эс бол буддын шашин ноёрхох шинжтэй бус харин дэлхийн олон шашны урсгал номлолууд зэрэгцэн орших болсон. Монголын баруун бүс нутгийн хүн амын дунд буддын шашин, бөө мөргөл, ислам шашнууд зонхилох байр суурьтай оршин байж харин уламжлалт бус тэр дундаа дэлхийн шинэ шашны хөдөлгөөний урсгал чиглэлүүд ч мөн үйл ажиллагаа явуулж байна. Бидний энэ судалгаа Баруун бүс нутаг дахь шашны байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг үйлийн үр дагаврыг тооцох, цаашид ямар эрх зүйн орчин байвал тэр нь зөв болох тухай асуудлыг авч үзэхэд оришино.*

* * * * *

Дэлхийн улс орнуудад улс төрийн бодлого ба шашин, төр ба сүм хийдийн хоорондын харилцаа, нөлөөлөл нь ээдрээтэй урт замыг туулж, чухлаар тавигдсаар иржээ. Шашин шүтлэг нь нийгмийн институт болохын хувьд төрөөс хавьгүй өмнө үүсэн бий болж, нийгмийн амьдралд болон хожим төр үүсэж нийгмийг засаглахад түүнд мөн адил янз бүрээр нөлөөлөх болжээ. Шашин, түүний байгууллага болох сүм хийд нь өөрийн корпоратив, өвөрмөц эрх ашигтай, түүнийгээ илэрхийлэх, хамгаалж хэрэгжүүлэх зорилго болон олон талын үйл ажиллагаатай.

Төрөөс шашны талаар явуулах бодлого нь Монгол орны үндэсний хөгжлийн ерөнхий үзэл баримтлалаас урган гарсан, түүнд тулгуурлагдсан байх ёстой. Өөрөөр хэлбэл, улс төр, эдийн засаг, соёлын хөгжлийн бодлого нь шашны талаар баримталж буй бодлого, хөтөлбөртэй нягт уялдах шаардлагатай. Нийгэм ба төрд шашны үзүүлэх нөлөө нь шашны байгууллага /сүм хийд/, лам нар /имам, пастер-номлогч/, сүсэгтнүүдийн /мусслим, итгэгч/ янз бүрийн нийгэмлэг, байгууллагын үйл ажиллагаа, түүнчлэн шүтлэгтнүүдийн өөрсдийн нь үйл байдлаар дамжин илэрч хэрэгждэг байна. Эл бүхий нөлөө түүхэн явцад эерэг ба сөрөг шинж, үр дагаварын аль алиныг агуулсаар иржээ.

Юуны өмнө бид шашны онцлог шинж чанарыг юу бүрдүүлдэг, ямар үзэл бодол, үзэл санаа, үйл ажиллагаа, байгууллагыг шашинд хамаатуулан ойлгох ёстой бэ? гэдгийг тодруулахыг хичээе. Түүхэн талаас нь харахад шашны судалгаанд эдгээр асуултын хариулт нь шашны суурь үндэстэй холбогдож, маргаан дэгдээж байдаг. Гэсэн хэдий ч бид шашны асуудлыг судлахын тулд 1-рт, Шашны ухамсарын хүрээ: сүсэгтний (итгэгч, мусслим) үзэл бодол, санаа сэдэл, мэдрэмж, туршлагын шинж чанарыг тайлбарлах хэрэгтэй. Шашны нөлөөний дор өдөр тутмын сахин мөрдөх зан үйлээр дамжин хуримтлагдсан туршлага нь хүний сэтгэхүйд мэдрэхүй, санаа бодол, сэтгэлгээ, дадал зуршил зэргээр тусгагдсан ухамсарыг төрүүлдэг байна. Энэхүү ерийн ухамсар нь үзэл

бодлын нэгтгэсэн систем маягаар бус, төсөөлөн мэдрэхүй, зориг эрмэлзлэл, сэтгэл хөдлөлийн үйлүүдээр илэрдэг. Харин шашны онолын ухамсар нь шашны үзэл номлол, ертөнцийг үзэхүйн уг сурвалжийг сэтгэлгээний дээд түвшинд ухааран, түүнийг хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг эзэмших замаар өөрийн оюуны удирдлага болгон тахин шүтэх ёсыг хэлдэг. 2-рт, Шашны үйл ажиллагаа: Шашны өвөрмөц байдлыг тахил, шүтлэгийн зан үйл, үйл ажиллагаатай холбож үзэх хэрэгтэй. Аливаа шашны тахил, шүтээний зан үйл нь: А. Тодорхой тахил, шүтээнгүйгээр явагдах буюу түүний эх сурвалжийг боловсруулах, шашны сурталчилгаа явуулах, шашны ёсыг заан сургах г.м. үйл үйлдлийн хэлбэртэй. Орчин үед цахим мэдээллийн хэрэгсэлийг өргөнөөр ашиглах болсон. Б. Тахил, шүтээнээр дамжуулан явуулах зан үйл буюу шашин номын ёсыг амьдрал дээр хэрэгжүүлэх үйлдэл болно. Энэ нь олон хэлбэртэй, тодорхой тогтсон дэг жаяг, арга хэрэгсэл, он, цаг хугацаатай, орон зайн нөхцлийг шаардсан байдаг онцлогтой. Тахил шүтээний агуулга нь тухайн шашны үзэл номлол, дэг жаягаас хамааран шашны ёсыг хатуу баримтлах журмаар гүйцэтгэгддэг. Тахил шүтээний хэрэгсэл нь буддын шашинд эрхи, даямар, хонх, цан, бадар аяга, зул, шавь хувцас г.м., христосын шашинд гэрээний хайрцаг, дал мод, дуулал, иссоп /цацал өргөх мод/ г.м., исламын шашинд озан дуудах, мацаг барих, угаалга үйлдэх, мөргөх г.м. байна. Тахил шүтээний арга нь шүтлэг явуулах хэм хэмжээ, үйлдлүүд Тухайлбал, мөргөлийн ёс, зан үйл, уншлага, баяр ёслолоос бүрддэг. /цам харайх, улаан өндөгний баяр, рамазан сар г.м./ 3-рт, Шашны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, онцлогийг авч үзэх шаардлагатай болно. Шашны оршин тогтнох, сүсэг бишрэлийг гүнзгийрүүлэх, хүн амыг шашны үйл хэрэгт оролцуулах, тахил шүтээн зан үйлийг гүйцэтгэх, нэгтгэх, бишрэлийг төрүүлэгч, ариун дагшин газар юм. Шашны байгууллагын гол зорилго нь гишүүддээ үйлчлэх, нөлөөлөх, тэдгээрт тодорхой зорилт, үнэт зүйл, үзэл санааг төлөвшүүлэхэд оршино. Үүнд: А. Үзэл номлол боловсруулах Б. Түүнийг хамгаалах, үнэн болохыг батлах /зөвтгөх/ систем, арга замыг хөгжүүлэх В. Тахил, шүтлэгийн үйл ажиллагааг чиглүүлэх, удирдах, хэрэгжүүлэх Г. Шашны ёс горим, дэг жаяг, зан үйл, хэм хэмжээг хэрэгжүүлэхэд хяналт тавих, хориг арга хэмжээ авах Д. Төрийн институтууд, иргэний нийгмийн байгууллагатай харилцаа холбоо тогтооход чиглэгдэнэ.

Шашны байгууллагууд орчин үед институцсэн, нийгмийн тодорхой бүлэг, нийтлэгийн эрх ашгийг хөндсөн, тэдэнд чиглэсэн тусгай арга хэрэгсэлээр дамжуулан үйл ажиллагаагаа удирдан явуулдаг болсон. Тухайлбал, шашны байгууллага /сүм хийд/ нь нийгмийн институтын статустай болж өөрийн гэсэн засаглал ба засаглалын дэд системтэй. Үүнд, Нэгдэх дэд систем нь шашны мэдээллийг боловсруулах, тогтсон үйл ажиллагаа, харилцааг өөрөө зохицуулах, тахил, шүтээний зан үйлийн хяналт, хориг арга хэмжээ, дүрэм журам боловсруулах ажлыг эрхэлдэг тусгай хүмүүс ажиллуулдаг. Хоёр дахь дэд системд сүсэгтэн /итгэгч, мусульман/ итгэгчдийн массыг багтаадаг. Эдгээр дэд системүүдийн хооронд явуулж буй үйл ажиллагааг удирдах боломжийг олгодог албан ёсны норматив, шаталсан тогтолцоо тогтвортой ажиллаж байдаг. Эдгээр харилцаа, зохион байгуулалт, институтийн хэм хэмжээ нь тухайн шашны байгууллагын бүтэц, сүсэгтэн /итгэгч/, лам хуврагууд, пастер, имам, шашны холбоодын удирдах байгууллагуудын хоорондын шатлан захирах ёс, удирдлага, эрх, үүргийг зохицуулдаг.

Шашны байгууллагын төлөвшилд тухайн нийгмийн бүтэц, улс төрийн хандлага, эдийн засгийн хэв маяг, уламжлалт соёл ба иргэншлийн хөрс суурь, эрхэлж буй аж ахуйн

зонхилох хэв шинж ихээхэн хамааралтай. Монголчуудын түүхэн талаас нь цухас хэд гурван жишээ дурдая. Жувейнегийн “Дэлхийг байлдын дагуулагчийн түүх” хэмээх түүхэн сударт иш татаж тэмдэглэснээр “Их засаг” хуулийн хоёр зүйлд (33, 34) шашны үйл хэрэг, харилцааг хуульчлан зохицуулж байжээ. Тухайлбал, гучин дөрөвдүгээр зүйлд: “Тэд шашин бүрийн хамгийн номтой санваартнуудыг аливаа татвар, алба гувчуурын дарамтнаас чөлөөлж, тэдний шашны эд хэрэглэл, өмч хөрөнгийг бүх нийтийн хэрэгцээнд зориулан, мөн тэдний харьяалалд байсан тариачдыг элдэв татвараас чөлөөлнө гэж зарласан” гэсэн бол гучин дөрөвдүгээр зүйлд “... аль нэг шашныг ялган гадуурхдаггүй, алиныг нь ч онцлон дэмждэггүй, цөмийг нь адилхан үздэг байлаа. Харин бүх шашны эрдэм номтой, үнэнч шударга санваартнуудыг хүндэтгэдэг, үүнийгээ бурханы хаанчлалд хүргэх баталгаа гэж үздэг байлаа. Түүнчлэн мусульманчуудад ивээлтэй ханддаг шигээ бас христийн болон бусад шашинд ч ивээлтэй ханддаг байв. Түүний хүүхдүүд, ач нар нь ямар шашин шүтэхээ өөрсдөө сонгоно. ... Тэд хэдийгээр өөр өөр шашинд орсон ч шашнаа улайран өмөөрч хоорондоо хямардаггүй, харин Чингис хааны Яаса хуулийг хэлбэрэлтгүй баримтлан эв эеэ их сахидаг байлаа”¹ гэжээ. Эндээс үзвэл “Их засаг” хуулиар шашны эрх чөлөө, янз бүрийн шашны тэгш байдлыг хангаж байсан, тэгэхдээ нийгмийн амьдралд хуулийг шашнаас илүү эрхэмлэн сахидаг, нэг шашныг хэт шүтэх фанатик үзэл гаргадаггүй байсан байна. Ийнхүү XIII зууны үед олон янзын шашин /сүм хийд/ зэрэгцэн оршиж байсан баялаг уламжлал бий гэж үзэх бүрэн үндэстэй. Мөн 1921 оны Ардын хувьсгал ялахаас өмнө “...шарын шашин, түүний олон зуун хүрээ хийд, хэдэн зуун мянган лам нар нийлбэр дүнгээрээ “улс доторхи улс”, “төр доторхи төр” гэж хэлмээр байдлаар өсөн өргөжиж, хүчирхэгжин ноёрхсоны дагуу сүм хийдүүдийн тоо эгнээ, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, шашин төрийн шинж агуулга хосолсон баяр ёслол, дээд лам нарын эрх ямба, тэдэнд үзүүлэх үйлчилгээ, шашны хэрэгт зарцуулах улсын санхүү төсөв зэрэг нь үнэхээр нүсэр болж улсын эдийн засаг, сүсэгтэн олны ахуй амьдрал, ажил төрөлд хүнд ачаа болж хувирсан байна”². Ийнхүү хувьсгалын өмнөх Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарилалт нь манжийн төрийн бодлогод нийцсэн цэрэг-засаг захиргааны шинж бүхий тогтолцоотой байсны дээр түүнд шашны хүч нөлөө ч багагүй тусаж өөрийн зохион байгуулалтын хэлбэрээ олж тогтсон байсан. Харин Ардын хувьсгал ялснаар аажмаар шашны бус иргэний боловсрол, шинжлэх ухааны хөгжил дэвшил, онцгойрох ач холбогдолтой болж, шашны үзэл номлол, үйл хэргийг хориглох, шахаж хавчих, хууль эрх зүйн орчноор хүчтэй хязгаарлах болж дан нэг намын ноёрхол, нэг үзэл суртал сурталдах болсноор 1990-ээд онтой золгосон байна.

Улмаар социалист систем задран унаснаар социалист чиг хандлагатай байсан улс орнуудын нийгэм, эдийн засагт өөрчлөлт орж, шинэ хэв маягт шилжих процесс явагдсан. Монгол Улсын шинэ ҮХ-д /1992 он/ иргэн хүний “шашин шүтэх, эс шүтэх” эрх чөлөөг баталгаажуулж өгсөн төдийгүй “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль” /1993/ -ийн 3-р зүйлд 1 дэх хэсэгт “Аливаа шашныг шүтэх, эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна”, 2 дахь хэсэгт “Иргэнийг шашин шүтэх, эс шүтэхэд албадах, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” хэмээн дэлгэрүүлэн заасан байна. Тухайлбал, 1990 оны 10-р сарын 07-нд “Ертөнцийн эзний чуулган” христосын шашны анхны цуглаан зохион

¹ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Нэгдүгээр боть (1206-1910). УБ., 2010, тал.32.

² Жамбал А. Монгол Улс дахь шашин шүтлэгийн эрх зүйн зохицуулалт (1206-1936). тал.76.

байгуулагдаж байсан бол эдүгээ Улаанбаатар хотод 240 гаруй, хөдөө орон нутагт 250 гаруй сүм, цуглаан, шашны байгууллага¹ үйл ажиллагаа явуулж байгаа мэдээ байна.

Нийгэм, соёлын орчин нээлттэй болсноор Монгол оронд уламжлалт шашны сүм хийд, дуган, хурал ном, мөргөлийн газрууд сэргэж зарим нь шинээр бий болж үйл ажиллагаа явуулах болсны зэрэгцээ гадны төрөл бүрийн шашны байгууллага /сүм хийд/ олноор байгуулагдах болсон. Энэ нь бидний өмнө өнгөрсөн уламжлалаа эргэн харж, үнэлэлт дүгнэлт өгөх, өнөөгийн байгаа нөхцөл байдлаа үнэн зөв, бодитойгоор цэгнэх, шинэ орчин нөхцөлийг тооцож, ирээдүйд чиглэсэн бодлого, хууль эрх зүйн орчноор зохицуулах гэх мэт олон асуудлыг гаргаж тавьснаар өнөөдөр буюу 30 орчим жилийг ардаа орхижээ. Хэдийгээр судлаачид шинжлэх ухаан, технологийн хөгжил, нийгэм соёл иргэншлийн хөгжил нь аажмаар шашны ухамсар, шашны тахил шүтээн, шашны байгууллагын үйл хэргийн улс орон, хүн амын оршихуй, аж амьдралд нөлөөлөл нь буурна гэж үзэж байсан боловч тийм хялбар шийдэж болох асуудал биш гэдгийг нэгэнт нотлоод байна. Харин ч техник технологи асар хурдацтай хөгжиж буй мэдээллийн эрин зуунд хүн төрөлхтний оюун санааны хэрэгцээ, шаардлага улам бүр өсөн нэмэгдэхийн хэрээр шашны байгууллагууд үйл ажиллагааны хэлбэр, зохион байгуулалтыг өөрчилж олон чиглэлд үйл ажиллагаа явуулах болсон байна. Орчин үед үйл ажиллагаандаа цахим орчин, мэдээлэл харилцааны технологийн дэвшил, онлайн сургалт гэх мэт төрөл бүрийн арга хэрэгсэлийг шашин суртачилахад ашиглах болсон. Шашны байгууллагууд дан ганц шашны үйл хэрэг эрхлэхээс гадна халамж, асрамж, хүмүүнлэгийн байгууллагууд, телевиз, радио, ном, сэтгүүл, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, сургалтын төв, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт нийгмийн олон янзын салбарт үйл ажиллагаа явуулж байна. Тэгэхээр энэ бүхнийг чухам хэрхэн ойлгох, хууль эрхзүйн ямар орчиноор зохицуулах, нийгмийн аль харилцаанд хамааруулах юуг хориглох, юуг хэрхэн дэмжих, шийдвэрлэх гэх мэт тулгамдсан асуудлууд гарч ирэх болсон.

Манай орны баруун бүс нутагт үйл ажиллагаа явуулж ирсэн шашны байгууллагын талаар энэ удаагийн судалгаанд авч үзэхийг зорьлоо. Энэ бүс нутаг нь Ховд аймаг, Баян-Өлгий аймаг, Увс аймаг, Завхан аймаг, Говь-Алтай аймгуудыг хамрах бөгөөд Монгол Улсын Ойрадууд болох өөлд, баяд, халх, захчин, урианхай, дөрвөд, хотон, тува, торгууд, хошууд гэсэн угсаатны бүлгүүдийн зэрэгцээ казахууд оршин амьдарч ирсэн нь шашин соёлын нэгэн өвөрмөц өнгө төрх, хэв шинжийг илэрхийлж байдгаараа монголын бусад нийслэл, бүс нутгуудаас ялгарах онцлогтой. Төв суурин буюу Улаанбаатар хотоос алслагдсан, олон угсаатны бүлгүүд эртнээс зэрэгцэн оршиж ирсэний зэрэгцээ тэдний шашин шүтлэг, хэл яриа, аялгуу, аман зохиол, уламжлалт үнэт зүйлийн ялгамжтай байдлууд өнөө хүртэл хадгалагдаж дахин давтагдашгүй байдлыг илэрхийлдэг онцлогтой. Мөн ялгамжтай байдлын хажуугаар нийтлэг нэгэн өвөрмөц онцлогийг ч тодорхойлох боломжтой юм.

Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хуульд “Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг /цаашид энэ хуульд “сүм хийд” гэх/ шашны

¹ Монголын нийгмийн оюун санааны академи ТББ. “Монгол Улс дахь христ итгэлт байгууллагууд” газрын зураг. УБ.,2018.

байгууллага гэнэ” хэмээн тодорхойлсон. Энэхүү хуулийн заалт болон бидний дээр өгүүлсэн бүхнээс нэгтгэн дүгнэж үзвэл хөгжингүй шашнууд нь шашны ухамсар, шашны үйл ажиллагаа, шашны байгууллагууд гэсэн гурван үндсэн элементийг багтаасан нэлээд нарийн бүтэцчилэгдсэн, зохион байгуулалтай, тогтолцоот үзэгдэл төдийгүй нэгийг нь нөгөөгөөс нь салгаж үл болох харилцан уялдаа холбоо бүхий, харилцан нэгнээ нөхцөлдүүлсэн нэг цогц асуудал юм. Бид шашны байгууллагыг онцлон түүгээр дамжуулан нөгөө хоёр элементийг тодруулах, тархалтыг тодорхойлох, үйл ажиллагаанд үнэлэлт өгөхийг хичээх болно.

Ер нь монголчуудын шашин шүтлэг, оюун сэтгэлгээний түүхэн уламжлалыг өнөө цагийн хэрэгцээтэй уялдуулан зүй зохистойгоор ашиглах, нийгэмд нэгэнт буй болсон уламжлалт бус /христос/, шинэ шашы хөдөлгөөнүүдийн дэлгэрэлтийн үйл явцад нөлөөлж буй хүчин зүйлс, асуудал бэрхшээл, шийдэх арга замыг нарийвчлан судлах шаардлагатай байна. Эдгээр олон шашны байгууллага /сүм хийд/-ийн үйл ажиллагааг цэгцлэх, сайн муу, зөв бурууг ялгах, буруу гаж урсгал буй агаас түүнийг хориглох, хоорондоо өрсөлдөөнт тэмцэлд орохоос сэргийлэх, нийгэм, соёлын зорилгод нэгтгэх, чиглүүлэх замаар нийгэм соёлын орчинд үр өгөөжтэй шашны эерэг нөлөөлөл буй эсэх, хууль эрхзүйн орчин ямар байх зэрэгт эрдэмжсэн, тоо баримттай судалгаа хамгийн чухал.

Судлаач С.Цэдэндамба Монгол дахь шашны байгууллагын талаар уламжлалт, уламжлалт бус, сургаал номлолын чиглэлээр нь 1. Буддын 2. Христийн 3. Исламын 4. Бусад буюу шинэ шашны хэмээн ангилсан¹. /Шинэ шашны хөдөлгөөний талаар ишлэл заагдсан бүтээлээс үзэх/ Мөн шашны байгууллагуудыг үүсгэл санаачлага албан ёсны эрх зүйн ямар хуулийн этгээд хариуцаж байгаа хэлбэрээр нь авч үзвэл: 1. Олон нийтийн үүсгэл санаачлага, хандив, тусламжаар байгуулагдсан 2. Гадны шашны байгууллагын үүсгэл санаачлагатай /АНУ, Солонгос, Япон, Норвеги, Турк г.м./ Эдгээр нь дотроо А. Нутгийн зөвлөл, ард иргэдийн хандив тусламж, өглөг Б. Хувь хүний санаачлага хөрөнгө мөнгөөр байгуулагдсан гэсэн төрөл хэлбэртэй байна. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, эрх мэдлийн тогтолцооны тухайд нь авч үзвэл өнөөдөр манай орны тухайд буддын шашны чиглэлээр “Монголын Бурханы шашинтны холбоо”, “Монголын бурханы шашинтны төв”, Монголын Буддист эмэгтэйчүүдийн “Буман ханд” холбоо, ислам шашны чиглэлээр “Монголын Мусульман нийгэмлэгүүдийн холбоо”, “Монголын Мусульманы нэгдэл”, “Елбырлийги” /Ард түмний нэгдэл эсвэл Ард түмний дуу хоолой орч./, “Оюутны алхам”, уламжлалт бус болон шинэ шашны хөдөлгөөний чиглэлээр “Монголын Библийн нийгэмлэг”, “Монголын Эвангелийн эвсэл”, “Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм”, “Монголын Бахайн нийгэмлэг”, “Христийн Монгол чуулган”, “Хаанчлалын сайн мэдээг тунхаглагчид”, “Христэд итгэгч Баптист сүмүүдийн холбоо” гэх зэрэг байгууллагууд Монгол Улсад төрийн бус байгууллагын статустайгаар шашны үйл хэрэг эрхлэн явуулж байна.

¹ Энэ талаар Алтайбаатар. Ж., Шинэ шашны хөдөлгөөнийг судлах арга зүйн хоёр хандлагын тухайд //Философи, шашин судлал. №19 (475) 2017. тал.134-144; Дэмбэрэл.С., Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөнүүдийн гишүүдээ нөлөөлөх арга, түүнээс сэрэмжлэх нь, //Философи, шашин судлал. №19 (475) 2017. тал.104-113; Пүрэвсүрэн.Ц., Монголын баруун бүс нутаг дахь шинэ шашны хөдөлгөөнүүд, ///Философи, шашин судлал. №308 (51) 2009. тал.291-304; үзнэ үү.

Эдгээрээс уламжлалт бус шашинд хамаарах төрийн бус байгууллага нь ХЗДХЯ /хуучин нэршлээр/ яамнаас зөвшөөрөл авч, дотроо ялгамжтай өөр өөр шашны урсгал чиглэлийг төлөөлдөг агаад дор бүрээ удирдлагын тодорхой толгой байгууллагатай, зохион байгуулалт нь бүс нутаг, аймаг, сум, баг, хороо гэсэн засаг захиргааны нэгжийн хувиарлалтад тулгуурласан босоо шатлалын, үйл ажиллагааны эмэгтэйчүүд, насанд хүрэгчид, багш, оюутан, сурагч г.м. хэвтээ түгээлтийн арга зарчимтайгаар өөр өөрсдийн сүм хийдээр дамжуулан үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ гадны хандив, тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын байгууллага руу чиглэсэн хөтөлбөр /Англи хэлний багш нарын холбоо, Дээрт, NLM г.м./ хэрэгжүүлж байна. Энэ шинж чанарыг буюу босоо, хэвтээ менежментийн арга технологи нь христосын үзэл номлолын уламжлалтай төрийн бус байгууллагад тодорхой илэрдэг. Тухайлбал, Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм нь (ХЗДХ-ийн сайдын 1994 онд анх) 2002 оны 03 дүгээр сарын 13-ны өдрийн 56-р тушаалаар улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгогдсон байна. Ховд аймгийн ИТХ-ын 1999 оны 06 сарын 24-ны 20-р тогтоолоор “Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн сүм улсын бүртгэлд бүртгүүлж үйл ажиллагаа явуулдаг энэрэлийн байгууллага тул Ховд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй” зөвшөөрөл авсан байна. Баруун бүсийн аймгуудад дээр дурдсан уламжлалт бус болон шинэ шашны хөдөлгөөний чиглэлүүдийн аймаг дахь салбар сүм хийд, чуулган, цуглаан, эсийн бүлгүүд ажиллаж байна. Ихэнхи шинэ шашны хөдөлгөөний чиглэлүүд өөрсдийгөө шашин бус урсгал, чиглэл хэмээн иргэдийг төөрөгдүүлнэ. Амьдралын боломж муу, ажилгүй, ганц бие өрх толгойлсон хүмүүс зэрэг нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн ажлуудыг явуулна. Аравны нэг буюу сарын орлогын аравны нэгтэй тэнцэх эсвэл хүн хэрэглэж болох зүйлсийг хандивлана. Авахаас өгөх нь илүү буян гэж ойлгуулдаг. Нэгэнт өнөөдөр уламжлалт бус шашны гүн сүсэгтэн, пастер, талархан дэмжигч нар бий болж нэн ялангуяа залуусын дунд өөрийн гэсэн байр суурийг эзэлсэн байна.

Баруун бүс нутагт уламжлалт бус болон шинэ шашны хөдөлгөөний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг шашны байгууллага: Ховд аймагт үнэн алдартны хоёр, шинэ шашны хөдөлгөөний 11 нийт 13, салбар цуглаан 7, Баян-Өлгий аймагт үнэн алдартны нэг, шинэ шашны чиглэлээр хоёр, Увс аймагт христосын нэг, шинэ шашны хөдөлгөөний чиглэлээр 5, Завхан аймагт шинэ шашны хөдөлгөөний чиглэлээр 5, Говь-Алтай аймагт шинэ шашны хөдөлгөөний 3 чиглэл байна. Нийт сүм хийд 30. Баруун бүсийн аймгийн төвд ойрхон, хүн ам олноор суурьшсан, хотжилтийн хэв шинж хөгжиж буй сум суурингуудад энэ чиглэлийн шашны байгууллагуудын сүм хийдүүдийн салбарууд байршдаг. Орон нутагт хэрэгжүүлж буй олон төрлийн хөтөлбөрүүд нь хүн амын дунд үр өгөөж өгч ашиг тусыг нь иргэд хүртэж, эсэргүүцэх, дургүйцэх, хэт ялгаатай байдлаар хандах хандлага ажиглагдах нь бага болсон. Эдгээр сүм хийд, цуглаанууд байнгын тогтмол үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ санхүүжилт нь гадны шашны байгууллага (олон улсын байгууллага сайн дурын г.м.), итгэгчдийн 10-ны нэгийн өглөгөөр бүрддэг.

Буддын шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллага сүм хийдүүдийн тухайд Монголын Бурханы шашны төв Гандантэгчилэн хийдэд нийслэлийн дүүрэг (9) болон аймгуудын сүм хийдүүдийн (21) тэргүүн нар, зарим хувийн сүм хийдийн төлөөллөөс бүрдсэн Тэргүүн лам нарын зөвлөл ажилладаг. Тэргүүн лам нарын зөвлөл нь Монголын Бурханы шашны бодлого, хэтийн төлөв, бие даасан байдал, эв нэгдэл, шүтэн бишрэх эрх, эрх чөлөөг дээдлэн хангахад чиглэгдсэн эрх барих дээд байгууллага юм. Мөн

зөвлөлийн хуралдаанаар бурханы шашны үйл ажиллагааны ерөнхий бодлого тодорхойлох, сахил санваар, винайн ёсыг сахиулахад анхаарах, дүрэм журам, дэг жаяг, сүм хийдийн үйл ажиллагааны стандарт батлах, хутагт хувилгаадын асуудал /уламжлалт тамга шарлуулах ёс/, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Дүүрэг болон аймгуудын хамба ламыг зөвшөөрч батламж, жанч, олбог /ямба/ өгнө. Харин дүүрэг, аймаг, орон нутгийн сүм хийдүүд хурал номын үйл хэргээ дээрх жаяг, гаргасан шийдвэр, бодлого чиглэлд нийцүүлэн өөр өөрийн онцлогийг харгалзан явуулна. Санхүүгийн тухайд сүм хийдүүд өглөгийн эзний хандив тусламж, үйл ажиллагааны орлого /ном хурах, буяны ажил/-оор санхүүжинэ. Буяны ажлын үнэ тарифийг өөр өөрсдөө тогтооно. Билгийн тооллын зуны эхэн сарын 15-нд Бурхан багшийн их дүйчин өдрийн хурал хурна. Энэ өдөр Бурхан багшийн мэндэлсэн, гэгээрсэн, бурханы хутаг нирваань дүрийг үзүүлсэн гурван үйл давхацсан бэлэг дэмбэрэлтэй өдөр байдаг. Эл өдрийг буддын шашинтай дэлхийн бүх улс орон тэмдэглэдэг. Богд Зонховын дүйчин өдөр буюу Зулын 25 (өвлийн эхэн сарын 25), Бурхан багшийн эхийн ачийг хариулсан өдөр, Өвлийн адаг сарын шинийн 24-с эхлээд 29-ныг хүртэл хурал хураад, Битүүнд Цэдэр Лхамд балин өргөх хурлыг хурна. Баруун бүсийн сүм хийдүүд шинийн 16-нд Майдар эргэх ёслол үйлдэж, хурал хурдаг онцлогтой. Сүүлийн үед бурханы шашны сүм хийдүүд нийгэм рүү чиглэсэн хүмүүнлэгийн болон бусад төрлийн хөтөлбөр хэрэгжүүлэх болсон нь нэн сайшаалтай. Мөн цахимаар хурал, ном хурах, номын утга холбогдол, үр дагавар, иргэдийг соён гэгээрүүлэх чиглэгийн ажлууд зохион байгуулж байна. Тухайлбал, Баруун бүсийн томоохон шашны байгууллагын нэг Ховд аймаг дахь Ганданпунцагчойлин хийд нь 2009 онд өглөгийн эздийн хандиваар байгуулагдсан. Хийдэд ловон лам-1, гэсгүй-1, унзад лам-1, зурхайч-1, балин тахилч-2, багш лам-2, хурлын лам-4, нийт 10, дээр нь нягтлан-1, манаач-1, цэвэрлэгч-1 гэсэн 13 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Лам нар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжахын зэрэгцээ хувиараа албан байгууллага, айл өрхөд ном унших, бусад буяны ажилд оролцсоны өглөгөөр санхүүждэг.

Баруун бүс нутагт буддын шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг шашны байгууллага: Ховд аймагт төв дээр хоёр, суманд 8 сүм хийд, Баян-Өлгий аймагт буддын шашны чиглэлээр төв дээр нэг, суманд хоёр, Увс аймагт төв дээр дөрөв, суманд 18, Завхан аймагт тав, суманд 25, Говь-Алтай аймагт төв дээр нэг, суманд 12 байна. Нийт сүм хийд аймгийн төвд 13, сумуудад 63 байна. Аймгийн төвийн сүм хийдүүд тогтмол үйл ажиллагаатай харин сумын сүм хийдүүдийн 30 орчим хувь нь тогтмол хурлын, ном уншдаг. Санхүүжилт нь ихэнхэдээ сүсэгтний хандив, буян номын үйл хэргийн хандив, өглөгөөс бүрдэнэ. Сум, орон нутгийн сүм хийдүүд нь анхандаа ихээхэн идэвхитэй, олон түмэн, нэр хүндтэй хүмүүсийн хандив тусламжаар баригдаж, тохижсон, ном, судар, бурхан шүтээн бүрэн боловч санхүү, үйл ажиллагааг удирдан явуулах лам санваартны бэрхшээл зэргээс зогсонги байдалд орж байна.

Ислам шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын анхных нь Монголын мусульманы нийгэмлэг бөгөөд 1990-ээд оноос Үндсэн Хуулиар “шашин шүтэх, эс шүтэх эрх” хуулиар баталгаажсантай зэрэгцэн ММН-ийг 1990 онд 10 сарын 5-ны байгуулжээ. Ислам шашин нь суннит, шийт, харижит гэсэн томоохон гурван урсгал, 20 гаруй чиглэлтэй байдаг. Манайд суннитийн чиглэлийн шашны байгууллагууд оршиж байна. Ихэнхи шашны байгууллагын санхүүжилт нь Арабын орнууд, Турк, Казахстан, Египет, Киргизстан улсуудын санхүүжилтээр баригдахын зэрэгцээ тэдний

дэмжлэг том байр суурь эзэлдэг. Исламын шашны байгууллагын гол бодлого шийдвэр, гадаад харилцаа, санхүүжилт болон бусад асуудлыг ММНХ-оос удирдан зохицуулдаг. 2000 он гарснаар шашны байгууллага /сүм хийд/, шашны сургууль, оюутан /эрэгтэй, эмэгтэй/ болон ЕБС-ийн сурагчдын дотуур байр гээд олон төрөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулах болсон. Исламын сүм хийдүүд нь барилга, байгууламж, өнгө үзэмжийн хувьд бүрэн тохижсон, иргэдэд байнгын нээлттэй байдгаараа онцлог. Баасан гарагийн мөргөлд настай эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхэд, залуучууд оролцох нь тогтмол, мөн шаардлага гарвал аян зам, ажил үйлс бүтээх дува /молда/ уншуулна. Сүмд буй өргөлийн хайрцаганд мөнгө хийнэ. Ислам шашинтны тухайд гадаадад боловсрол эзэмшсэн имамууд буцаж ирээд багшлах болон шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулах болсонтой холбоотой “халал”¹-ын асуудал чухал болсон. Монголд буй исламын байгууллагын хүмүүс “халал” стандартыг боловсруулж гаргасан төдийгүй бэлтгэх үйлдвэр, сүлжээ дэлгүүрүүд ажиллаж байна. Ихэнхи мусульманчууд ислам шашны таван багана буюу 1. Гэрчлэл. Энэ нь ислам шашинтны нийтлэг бэлэг тэмдэг “шахада” /итгэлийн тунхаглал/ буюу “Аллахаас өөр ямар ч бурхан байхгүй мөн Мухаммед Аллахын элч мөн болохыг би гэрчилж” гэсэн утгатай. 2. Мөргөл. Мусульманчууд хүн мөргөл үйлдэх ёс болох салаат (СА-лаат)-ыг өдөрт таван удаа биеэрээ үйлддэг үйлдэл юм. Баасан гарагийн үд дундын мөргөлийг эрэгтэй хүн бүхэн заавал хийх ёстой. 3. Өргөл. Закат (за-каат, ариусгагч хүч)-ийг мусульман хүн заавал өгөх ёстой бөгөөд энэ нь өөрт илүүг бусдад түгээх, хуваалцах үйлдэл юм. Зарим оронд нийт хөрөнгийнхөө 2,5 хувь хүртэл өгөх ёстой бол заримд нь заавал шаарддаггүй /боломжоороо/. Манайд бол нэг хүн тодорхой мөнгөн дүнгээр өгөхөөр зохицуулагддаг. Жишээлбэл, Баян-Өлгий аймгийн Дэлүүн суманд насанд хүрсэн хүн 5000, хүүхэд 3500 төгрөг түүнээс дээш өгдөг жишиг тогтсон байна. Үүнийг сайн дураар тухайн шашны байгууллага зохион байгуулна. 4. Мацаг барих. Жил бүр билгийн тооллын Рамадан сард нар мандахаас жаргах хүртэл мусульманчууд хоол, унд, бэлгийн харьцаанаас татгалздаг. Мөн уг сарын турш ядууст, онцгой буяны үйлсэд өөрсдийгөө зориулж Коран уншдаг. 5. Мөргөл үйлдэхээр явах. Чин сүжигтэй жинхэнэ мусульман хүн, хөрөнгө мөнгөний боломж, тохироо бүрдвэл амьдралдаа дор хаяж нэг удаа Мекка руу мөргөл үйлдэхээр явж мөргөх ёстой. Энэ нь асар их нэр хүнд, ариун үйлс /сүнслэг/ үйлдэл мөн. Монгол орны хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ислам шашны байгууллагууд боловсон хүчин санхүүжилт, байр сууц, менежментийн тухайд маш сайн, төдийгүй казах иргэдийн оршин амьдарч буй газар оронд дор хаяж нэг сүм хийд байгуулагдсан буй. Шашны сүсэгтний тухайд “казах хүн ислам шашинтан байх ёстой” гэсэн бичигдээгүй дүрэм яс үйлчлэх агаад өөр шашинд орохыг хатуу хориглох хандлагатай. Тухайлбал, манайд буй исламын шашны байгууллагын ихэнхи нь казахууд олноор оршин амьдардаг Баруун бүс нутгийн Баян-Өлгий, Ховд аймгуудад байна. Тэдний сүм хийдийн олонхи нь ММНХ-д харьяалагддаг.


Баруун бүс нутагт ислам шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг шашны байгууллага: Ховд аймагт төв дээр гурав, суманд 4 сүм хийд, Баян-Өлгий аймагт ислам шашны чиглэлээр төв дээр 19, суманд 26, Увс аймагт суманд 1, Завхан аймагт байхгүй, Говь-Алтай аймагт байхгүй байна. Нийт сүм хийд аймгийн төвд 22, сумуудад 30 байна. Аймгийн төвийн, сумуудын сүм хийдүүд тогтмол үйл ажиллагаатай. Мөргөлийн цагаар озан дуудах гэх мэт зан үйл тогтмол явагдана. Ислам шашны чиглэлийн сүм хийдүүдийн

¹ Халал хоол хүнс нь Исламын зарчмуудын дагуу мусульман хүний хооллож болох хүнсийг хэлнэ.

аймгийн төвийнх тогтмол, харин сум, суурин, багийн төвийн 80 орчим хувь нь тогтмол ажилладаг.

Баруун бүсийн шашны байгууллагын тоо баримт, тархалт: Өнөөгийн засаг захиргааны нэгжийн хувиарлалтаар “Монголын сүм хийдийн түүхэн товчоо” (2007) төслийн хүрээнд бүртгэгдсэн сүм хийдийн тоо Завхан аймагт 35, Говь-Алтай аймагт 25, Увс аймаг 12, Ховд аймагт 22, Баян-Өлгий аймагт 9 Нийт 103 сүм хийдийн туурь бүртгэгдсэн байна¹. Харин Баян-Өлгий аймгийн тухайд “1930 он хүртэл аймгийн хэмжээнд 14 сүм үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд үүнээс ислам шашны 10, буддын шашны 4 сүм үйл ажиллагаагаа явуулж ард түмний дунд шашнаа сурталчлах, хөгжүүлэх янз бүрийн ажлууд хийж...”² байжээ.

1990-ээд оноос хойш Монгол Улсын Статистикийн ерөнхий газраас жил бүрийн эцэст шашны байгууллагын төрөл, хэлбэрээр статистик судалгаа гаргадаг болсон. Энэ удаад өөрийн судалгааны хүрээнд олж цуглуулсан баримт болон хээрийн шинжилгээний материалд тулгуурлан авч үзье. Орчин үеийн шашны байгууллагын төвлөрөл нь хүн амын төв рүү тэмүүлэх хүч буюу нүүдэл, шинэ залуу суурингууд, аймгийн төв, нийслэл, хотуудад олноор үйл ажиллагаа явуулах болсон. Монгол бол залуучуудын орон /хүн амын 70 орчим хувь/ тэд суурин газарт олонхи болж оршин амьдардаг, томоохон соёл боловсролын байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг, зарим амьдралын нөхцөл байдал доройтсон иргэд ихэнхидээ суурин газар руу шилжин суудаг зэрэг нь шашин байгууллагынханд боломж олгодог. Үүнтэй холбоотой баруун бүсийн аймгийн төвүүдэд аль ч шашны чиглэл, шашны байгууллагын томоохон сүм хийдүүд оршин байж тогтмол, тасралтгүй үйл ажиллагаа явуулах бололцоог бүрдүүлдэг. Үүнд, үндэслэн аймгийн төв, сум гэсэн ангиллаар асуудал хандвал нийт сүм хийдийн 40 орчим хувь аймгийн төвд, үлдсэн нь буюу 60 орчим хувь нь сум, суурин, багийн төвд байна.



Баруун бүс нутагт 2020 оны байдлаар 4036648, Ховд аймагт 87954, Баян-Өлгий аймагт 103280, Увс аймагт 82758, Завхан аймагт 72260, Говь-Алтай аймагт 57412 хүн оршин амьдарч байна. Бүс нутгийн 2554 хүн тутамд нэг сүм хийд ноогдож байна. Баян-Өлгий,

¹ www.google.com

² “Мусульманы нийгэмлэг 20 жил” УБ.,2010. тал.15-16.

Завхан аймгууд 2065 хүнд нэг сүм хийд ноогдож байгаа нь бусад аймгуудаас өндөр үзүүлэлттэй байна. Мөн Ховд аймаг уламжлалт бус шашны тоогоор, Завхан аймаг буддын шашны сүм хийдийн тоогоор, Баян-Өлгий аймаг исламын сүм хийдийн тоогоор тэргүүлж байна. Аль ч аймгийн төв сууринд буй шашны сүм хийдүүд сумуудад байгуулагдсан сүм хийдүүдийн /буддын, исламын/ ихэнхи нь ивээн тэтгэгч байгууллага, хувь хүний хөрөнгө, ард иргэдийн хандив тусламжаар байгуулагдсан 1990-ээд оны үед ойролцоогоор 5 түүнээс дээш сая төгрөгөөр бүтээн байгуулагдаж байсан бол сүүлийн үед 50 сая түүнээс дээш мөнгөн дүнтэй байна. Сум, орон нутагт байгуулагдсан буддын сүм хийдүүдээс аймаг тус бүрд хоёроос гурав нь үйл ажиллагаа тогтмол явуулахын зэрэгцээ бусад нь хайхрах эзэнгүй шахуу үрэгдэж байна. Учир шалтгаан нь 1990-ээд онд амьд сэрүүн байсан лам хувраг нар цагийн аясаар нутаг буцсан, шинэ залуу боловсон хүчин нэгээс хоёр жил ажиллаад амьдралын эрхээр хот, суурин газар шилжсэн, санхүүгийн бололцоо хязгаарлагдмал, орчин үеийн лам нар өмнөх үеийнх шиг дан ганц шашин номын үйл эрхэлдэг бус эхнэр, хүүхэдтэй болсон тэднийг тэтгэх, авч явах хөрөнгө мөнгө, цалин шаардлагатай болдог зэрэг нь бэрхшээл үүсгэдэг. Гэтэл бусад шашны байгууллага, сүм хийдүүд удирдлагын томоохон бүтэц, дэд системтэй, ислам шашны сүм хийдүүд боловсон хүчин бүрэн хангагдсан, мөргөл тогтмол хийдэг, тохижилт үнэхээр сайхан хийгдсэн, хариуцах эзэнтэй, гадны тодорхой байгууллагаас санхүүждэг зэрэг нь давуу байдлыг олгож байдаг. Сүсэгтний /итгэгч, мусульман/ судалгаа, үйл ажиллагааны төлөвлөгөө, нарийн тогтсон мөргөл, цуглааны хувиарт өдрүүдтэй. Мэргэжлийн номлогч, имам нар ажилладаг, сүмийн хаалга аврагдахыг хүссэн хэн бүхэнд нээлттэй. Баруун бүсийн сумуудад үйл ажиллагаа явуулж буй уламжлалт бус, шинэ шашны хөдөлгөөнүүдийн зонхилох нь гэр цуглаан, чуулганууд түгээмэл болсон. Тухайлбал, Ховд аймгийн Манхан суманд 10 орчим жил сайн мэдээ хүргэж буй “Баярын мэдээ” чуулганд байнгын 20 гаруй, тогтмол бүртгэлтэй 10 орчим хүн хамрагддаг¹.

Баруун бүс нутагт сумын төвд байршилтай сүм хийдүүдээс Ховд аймагт 4, Увс аймагт , Завхан аймагт , Говь-Алтай аймагт хийдүүд хурал хурах, буяны ном хурах чиглэлээр харьцангуй тогтвортой ажиллаж байгаа бол бусад нь үйл ажиллагаа нь бүрэн зогссон байна. Орон нутаг, суманд байгуулагдсан сүм хийдүүд нь нэг талаас шашны байгууллага мэт боловч монголчуудын биет болон биет бус соёлын өв, ариун дагшин газар орон, соён гэгээрлийн ил уурхай юм. Энэ сүм хийдүүд нэг бүр нь дунджаар 50 орчим сая төгрөг түүнээс дээш хөрөнгөөр бүтээгдсэн, уламжлалт монгол дарханы ур ухааныг шингээсэн, нүүдэлчдийн олон мянган жил бүтээсэн судар ном, бичиг үсгийн дурсгал хадгалагдсан, нэгэн цаг, нэг хүний түүх бус харин гурван цагийн хэлхээгээр холбогдсон, нийт монгол түмний шавхагдашгүй түүх, үнэт баялаг мөнөөс мөн бөлгөө. Монгол Улсын Үндсээн хуулинд: “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ”, Төр сүм хийдийн харилцааны тухай хуульд “Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй” гэж заасан буй. Энд нэг зүйлийг зориуд дурдахад уламжлалт шашны сүм хийдүүдэд төрөөс нэг удаа дэмжлэг үзүүлэх, тодорхой соёлын бодлогод тусгаж санхүүгийн хувьд дэмжих нь ямар ч хууль эрх зүйд нийцэх учиртай.

¹ Хувийн архив

Сүүлийн 30 орчим жилд манай оронд шашны асуудлыг ардчилал нэрийн дор хэт чөлөөтэй орхисон, нийгэм эдийн засаг, төр засгийн тогтворгүй байдал, гадны зээл, хандив тусламжийг хэт шүтсэн, бүх зүйлийг эдийн засаг, санхүү, мөнгө, ашиг хонжооны нүдээр хардаг, төрийн байгууллагаас тавьдаг хараа хяналт, шаардлага, хариуцлага сул зэрэг шалтгаануудаас үүдэлтэй уламжлалт соёл ахуйг үгүйсгэхийн зэрэгцээ гадны янз бүрийн шашны байгууллагууд үйл ажиллагаа явуулахад хүргэсэн. Хэдийгээр гадны улс орон, төрийн хийгээд хувийн хэвшил, хувь хүмүүсийн янз бүрийн ашиг сонирхол, санхүүгийн давуу байдал зэрэг асуудлууд, шалтаг, шалтгаан байгаа хэдий ч биднээс хамаарах нь арай илүү их жин дарах нь тодорхой. Манай улс шашны олон янзын урсгал чиглэлийн харилцааг зохицуулж ирсэн хууль эрх зүйн хийгээд соёлын өвлөгдөн ирсэн уламжлалтай ард түмэн. Иймд шашны байгууллагын асуудлыг зөнгөөр нь орхих бус тодорхой бодлого, шийдвэр, хууль эрх зүйн орчны шинэчлэлтэй уялдуулан зохицуулах шаардлага зүй ёсоор бий болоод байна. Ингэхдээ Үндсэн Хууль, Төр сүм хийдийн харилцааны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг цаг үе, нөхцөд байдлыг харгалзан монгол үндэстний эрх ашигт нийцсэн, бусад шашин, соёлын ашиг сонирхлыг хүндэтгэсэн зарчмаар хандах нь чухал юм. Олон мянган жилийн уламжлалт соёлын дахин давтагдашгүй үнэт өвийг хамгаалах, тэр нь хуучны буддын шашны байгууллага, сүм хийд, иргэдийн гар дээр буй биет соёлын өв ном судар, бурхан шүтээн, биет бус соёлын өв цам харайх, уул ус, овоо тахих, шинийн нэгэнд дээр мөргөх г.м. үнэт зүйлсийг хамгаалах, хадгалахад, уламжлуулан үлдээхэд дорвитой бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Тухайлбал, иргэд, хувь хүний гар дээр хадгалагдаж буй, мөн орон нутаг сум суурингийн сүм хийдүүдэд байгаа ном судрууд, бурхан тахилыг бүртгэх, хамгаалах, шинжлэх ухааны эргэлтэнд оруулах асуудал нэн түрүүнд шийдвэл зохилтой асуудал болоод байна.

Энэ бүхэн нь аль нэг шашны асуудлыг нэгийг нь нөгөөгөөс нь ялгаж, гадуурхаж буй хэрэг огтхон ч биш. Харин шашин бол зөвхөн сүсэг бишрэл, итгэл үнэмшил, шүтээнд мөргөх, ном судар унших, мөргөх залбирах үйл төдий биш тухайн үндэстний бий болгосон соёл ба иргэншлийн дахин давтагдашгүй үнэт зүйл болох тухайд нь ойлгох хэрэгтэй. Монгол орноо буддын шашин дэлгэрсэн цагаас эдүгээ хүртэлх түүхэн янз бүрийн нөхцөл байдалд уг шашин соёл нь тэдний өдөр тутмын ахуй амьдрал, төр засаг, билэгдэлт үзэл, оюун сэтгэлгээ хийгээд оршихуйн нандин шижим, үнэт зүйл болон өнөөг хүртэл оршин хөгжиж ирсэн хийгээд цаашид ч байсаар байх болно.

Нэн ялангуяа хувьсгалаас өмнө оршин байсан сүм хийдийн туурийг хадгалалт хамгаалалтанд авах, тэнд уг хийд оршин байсныг илтгэх тэмдэг тэмдэглэгээ хийх, шинэ тутам байгуулагдсан сүм хийдүүдийг соёлын өв, үнэт зүйл болох талаас үнэлгээ хийх, бүртгэл, хамгаалалтанд авахад анхаарах хэрэгтэй юм. Нүүдэлчин монгол түмний даяаршилын давалгаанд автуулахгүй авч үлдэх биет болон биет бус соёлын өвийн олон шижим, нандин зүйлс тэдний шашин суртахуунд багтаж Тухайлбал, урлаг, урлахуйн ухааны уламжлал, уртын дуу, яруу найраг, уул овоо тахих зан үйл гэх мэтэд цогцлон шингэсэн байдаг.

Монголын баруун бүс нутаг нь буддын, исламын, христосын уламжлал бүхий католик, үнэн алдартаны зэрэгцээ шинэ шашны хөдөлгөөний чиглэлүүд идэвхитэй үйл ажиллагаа явуулж тэд тус бүр өөрсдийн орон зайг баттай бий болгохоор өрсөлдөж байна. Иймд цаашид хууль эрх зүйн орчны хэрэгжилт, шашны байгууллагын харилцан ойлголцол, өрсөлдөөнт тэмцэлд орохоос сэргийлэхэд анхаарах хэрэгтэй. Нэн ялангуяа

христосын уламжлал бүхий урсгал, шинэ шашны хөдөлгөөний урсгал чиглэлүүд итгэгчдээ булаалдах, хэт хатуу хянах, өөртөө хамаатуулах, харьяалах өөр шашинд бүх бурууг тохох, хэт олон итгэгч элсүүлэхийн төлөө хуулиас гадуур үйл ажиллагаа явуулах зэрэг зохисгүй зүйлийг гаргахгүй байхад анхаарах нь чухал. Ислам шашинтнууд “казахууд” үндэс угсаа нэг гэсэн утгаар өөр шашны цуглаанд очих, харилцаа тогтоохыг зөвшөөрдөггүй. Шашны үзэл номлолоо сурталдах, түгээхдээ бусад шашны үйл хэргийг үгүйсгэх, гутаах, буруутгах, өөрийн үзэл номлол шашныг дөвийлгөхийн зэрэгцээ манайх бол шашин бус, хүмүүсийг аз жаргалтай амьдралд хүргэх, сайн сайханд хөтлөх урсгал, байгууллага гэх мэтээр иргэдийг төөрөгдүүлэх явдал ч байсаар байна. Чухам яагаад шашнаа шашин биш гэх болов гэдэгт “шашин бол ард түмнийг мунхруулагч хар тамхи” гэх ойлголт өдгөө ч амь бөхтэй буй, мөн 1990-ээд онтой зэрэгцэн үндсэрхэг үзэл, уламжлалт үнэлэмж хүчтэй сэргэсэн нь иргэдийг “гадны шашинд тааламжгүй хандах”-д хүргэсэн зэрэг нь гол шалтгаан болж байна. Тэгэхээр цаашид шашин хоорондын зөрчил гарахаас сэргийлэх, шашны сүсэгтэн /итгэгч, мусульман/ нарын үзэл бодлын зөрүү, үл хүндэтгэх байдал, хүний эрхийг зөрчих, хэт фанатик үзэл дэлгэрэхээс урьдчилан сэргийлэхэд анхаарч, зохицуулж байх хэрэгтэй. Нэмж өгүүлэхэд монголчууд бид хувьсгалаас өмнөх соёлын биет болон биет бус өвийг өөрсдийн хариуцлагагүй байдал, бусдын зааварт хэт шүтсэнээс нэлээдгүй нь устаж үгүй болсон. Харин сайн цагийн эрхээр олон түмэн, буянт хүмүүсийн хандив, тусламж, санаа санаачлагаар эргээн сэргээгдсэн энэ их өв, үнэт зүйлээ үнэгүйдүүлж, үрэн таран хийж болохгүй. Яг манай оронд өнөөдөр уламжлалт өв соёлд суурилан, үнэт зүйлийн цогцолбор, дахин давтагдашгүй баялаг болон сүндэрлэж, гурван цагийн хэлхээст хөгжиж ирсэн нь буддын шашин соёл бөлгөө. Бусад нь шинэ тутам зүйл болохыг хэн ч үл маргах буй заа. Иймд төр засаг эдгээр сүм хийдэд нөхөн олговор олгох, хууль эрх зүйн орчин, эдийн засгийн хөшүүрэг, соёлын бодлогоор дэмжих хэрэгтэй юм. Сайн цагийн салхины сэвшээнд Монгол газраа энх амгалан, уламжлалт үнэт өв соёл өнө мөнхөд орших болтугай.

ABSTRACT

Today, in Mongolia, in connection with the fact that religious belief has been free since 1990s, it is not just an atheism, nor is Buddhism dominant, but there are world's many religious sermons. Among the population in the western region of Mongolia, Buddhism, Shamanism and Islamic religions have been dominant, while the non-traditional ones, especially the world's new religious sects are also operating. This study of ours is to assess and analyze the activities of religious organizations in the Western region, to estimate the consequences or outcomes of positive and negative impacts on the society, and to consider the right or proper legal environment to be created in the future.

НОМЗҮЙ

1. Алтайбаатар Х. Шинэ шашны хөдөлгөөнийг судлах арга зүйн хоёр хандлагын тухайд // Философи, шашин судлал. №19 (475). УБ.,2017. тал.134-144.
2. Дэмбэрэл С. Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөнүүдийн гишүүддээ нөлөөлөх арга, түүнээс сэрэмжлэх нь //Философи, шашин судлал. №19 (475). УБ.,2017. тал.104-113.

3. Жамбал А. Монгол Улс дахь шашин шүтлэгийн эрх зүйн зохицуулалт (1206-1936). УБ.,2012
4. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Нэгдүгээр боть (1206-1910). УБ.,2010,
5. Пүрэвсүрэн. Ц. Монголын баруун бүс нутгийн хүн амын шашин шүтлэгийн төлөв байдлын талаарх нийгмийн философи шинжилгээ (Докторын зэрэг горилсон бүтээл), /МУИС-ийн номын сан/ УБ.,2013
6. Пүрэвсүрэн Ц. “Монголын баруун бүс нутаг дахь шинэ шашны хөдөлгөөнүүд” /// Философи, шашин судлал. №308 (51). УБ.,2009. тал.154-164.
7. О.Чимэг. Протестант шашин. //Философи, шашин судлал. УБ., 2009.№318 тал. 55/ 93 дахь тал
8. Шинэ гэрээ. Матай. 28.18
9. Теологийн товхимол. Библийн сургалтын төв. Нийтлэгчид: Түмэнбаяр Г., Өлзийжаргал Б. ... нар. // ред. Пүрэвдорж Ж. УБ.,2016
10. <https://www.jw.org/mn/-/Еховагийн> гэрчүүд албан ёсны вэб сайт. Монгол хэл дээр/

Хавсралт.

Зураг 1.Баруун бүс нутагт буй /суманд/ зарим сүм хийдийн зурагнууд: /Буддын шашны сүм хийдүүд/



Хавсралт. Зураг 2. Баруун бүс нутагт буй /суманд/ зарим сүм хийдийн зурагнууд:
/Исламын шашны сүм хийд/



Хавсралт. Зураг 3. Баруун бүс нутагт буй /суманд/ зарим сүм хийдийн зурагнууд:
/Христосын шашны сүм хийд/

